

Авлигатай тэмцэх газраас зарласан “МИНИЙ САНАЛ: АВЛИГАГҮЙ МОНГОЛ” (АСУУДАЛ, ШИЙДЭЛ) сэдэвт эсээ бичлэгийн уралдааны II байрын бүтээл

Ц.ЧОЙЖАМЦ

АВЛИГЫН ЭСРЭГ СТРАТЕГИЙН БОДЛОГО

/Миний санал: Авлигагүй Монгол (Асуудал, шийдэл)/

Авлига хэмээх нүдэнд үзэгддэггүй нийгмийн хорт хавдар урагшилдаг бүхний замд чөдөр өвс мэт саад болж байна. Өвөг дээдсийн маань төр засаг “дайн үрэгдсэн цэргийн ар гэр, үгээгүй ядууст тэтгэмж тусламж болгож 100 хонь тутмаас 1 хонь татварлан авч иргэддээ өгдөг байсан” энэрэл нигүүсэхүйн өглөгийг “авлига” хэмээн нэрийддэг байсан нь өдгөө эсрэгээрээ байраа сольж “төрийн албан тушаалтан хийх ёстой зүйлийнхээ төлөө иргэдээс шан харамж авч олон нийтийг хохироодог эдийн засгийн далд гэмт явдал”-ыг авлига хэмээдэг болжээ.

Энэхүү авлига хэмээх нийгэм эдийн засаг, улс төр, хууль эрх зүйн салбарыг бүхэлд нь хамрах гэмт явдлын хор уршиг, сөрөг үр дагавар нь иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлж, нийгмийг сульдааж, эдийн засгийн өсөлтийг сааруулж, улс орны хөгжлийг удаашруулж, шударга ёсыг үгүйсгэн, иргэд олон нийтийн төрд итгэх итгэлийг алдагдуулж байдаг олон сөрөг талтай. Тиймээс дэлхий нийтээрээ энэхүү эдийн засгийн далд гэмт хэргийн эсрэг тэмцэхээр олон арга,үйл ажиллагааг сэдэж хэрэгжүүлж байгаа ч тэрхүү гэмт хэргийн эзэд нь өөрсдөө улс төр, эрх мэдлийн оройд сууж байдаг тул амар хялбар үр дүнд хүрэх боломжгүй байсаар байна. Энэ нь авлигатай тэмцэх өөр дэвшилтэт шинэлэг арга замыг хайх шаардлагатай байгааг эрх биш бодогдуулна.

Авлига нь нууцлагдмал далд үйлдэгддэг тул илрүүлэхэд нэн төвөгтэй гэмт хэрэг бөгөөд үүнийг дэлхий нийтэд цагаан захтны гэмт явдал/misconduct/ гэж нэрлэдэг. Авлигын гэмт хэргийн субъект нь эрх мэдэлтэн, албан тушаалтан байдаг бөгөөд тэдгээр нь үүргээ үл хүндэтгэн ёс зүйн хэм хэмжээг зөрчдөг. Хийх ёстой ажил үүргээ

гүйцэтгэснийхээ төлөө эсхүл эс гүйцэтгэснийхээ төлөө бусдаас шан харамж авах нь албан тушаалтны ёс зүйн зөрчилд шууд хамаарна. Нийгмийн шинжлэх ухааны үүднээс авч үзэх юм бол авлига нь ёс зүйн хүрээний асуудал болохынхоо хувьд “нийгмийн гаж үзэгдэл” болдог.

Бидний амьдарч буй нийгэм нь өөрийн салбараа үнэлдэг үнэлэмжтэй, үнэлэмжийн шалгуур үзүүлэлттэй, салбарынхаа үзэгдэл, үйл явц, цаашдын хандлагыг таамаглаж тодорхойлон, нөлөөлж засаж залруулдаг аргатай, мэдлэгийн өргөн цар хүрээтэй байдаг.

Авлига нь нийгмийн үзэгдэл дотроо багтаж байгаа үзэгдэхүүн болохынхоо хувьд нийгмийн шинжлэх ухааны аргаар засаж залруулж болох үзэгдэл юм гэсэн философийн дүгнэлт гарч ирж болох юм.. Өөрөөр хэлбэл нийгмийн ухааны салбар дотор ёс зүй багтдаг, ёс зүйн доголдол нь авлигыг бий болгодог. Тиймээс авлига нийгмээс үүдэлтэй, нийгэмд багтдаг тул **нийгмийн алдаа дутагдлыг засах замаар авлигыг үгүй болгож болно** гэсэн логик-онолын гаргалгааг гарган тавьж байгаа юм.

Нөгөөтэйгүүр авлигын гэмт хэргийг үйлдэж байгаа субъект бие хүн/хувь хүн/ нь нийгмийн элемент буюу нийгмийн гишүүн байдаг бөгөөд түүний зан үйлийг зохицуулах хууль тогтоомжоос гадна хуулиар зохицуулагддаггүй ёс суртахууны хэм хэмжээнүүд өөр дотор нь үйлчилж байдаг. Жишээлбэл шашин шүтдэг хүн байлаа гэж бодоход “авлига авах нь буруу, буруу зүйл хийвэл нүгэл болно, нүгэл үйлдвэл тамд унана” гэх тэр хувь хүний шашны ухамсар нь авлигын гэмт хэрэг үйлдэхээс өөрийг нь чөлөөлж байдаг. Энэ бол хувь хүний өөрийнх нь ёс зүйн үнэлэмжийн хэмжүүр юм. Бас тэр хүний ёс суртахууны үнэт зүйл нь юм. Огт үнэт зүйлгүй, үнэлэмжгүй, үнэлэмжийн хэмжүүргүй бол тэр бие хүн нүгэл буяны зааггүй, сайн муугийн дэнсгүй, цээрлэх хориглох зүйлгүйгээр хүссэнээ үйлдэх болно.

Тэгэхээр нийгмийн гишүүдийг хууль зөрчиж муу зүйл хийхээс хязгаарладаг хүчин зүйл бол төрийн хуулиас гадна өөрийнх нь дотоод орчинд үйлчилдэг ёс зүйн хууль байдаг. Энэ ёс зүйн хуулийг юун дээр тулгуурлаж өөртөө бий болгох нь тухайн

хувь хүний өөрийн ухамсар, төлөвлөөс хамаардаг. Боловсролоос олж авсан ёс зүй, шашин шүтлэгээс үүдсэн ёс зүй, өөрийн зөн мэдрэмж болон байгаль нийгмийн бусад нөлөөллөөс олж авах гэх мэт. Хамгийн гол нь тэр ёс зүйн хэмжүүр нь хувь хүнийг, нийгмийн гишүүнийг биеэ зөв авч явахад нь тусладаг, нийгмийн үнэт зүйл нь болж чаддаг, нийгмийн шударга ёсны хэмжүүр болдог, үнэлэмжийн хүчин зүйл байх ёстой. Нийгмийн нийтлэг үнэт зүйл, үнэлэмж, түүний хэмжүүрийг тодорхойлж, нийгмийн нийт гишүүд/иргэд/ нэг баримжаатай ижил ойлголттой болох нь чухал байна. Үүний илрэх хэлбэр бол нийтээр заавал дагаж мөрдөх бие даасан кодекс/төрөлжсөн хууль/ юм. Тодруулбал нийт нийгэм, иргэдийн ёс зүйд нөлөөлөх нэгдсэн ойлголт бүхий үнэлэмжийн хэмжүүр, хэм хэмжээ.

Нийгмийн гаж үзэгдэл бий болоход ч, эрүүгийн гэмт хэрэг гарахад ч түүнийг гарахад нөлөөлсөн ямар нэг хүчин зүйл заавал байдаг. Өөрөөр хэлбэл шалтгаан нөхцөл. Үүнийг судалдаг ухааныг хууль зүйн шинжлэх ухаанд “криминологи” буюу гэмт явдал судлал гэж томъёолдог. Тодруулбал нийгэмд авлига юунаас болж гараад байна, авлигын гэмт хэрэг яагаад гардаг вэ гэдгийн учир шалтгааныг гэмт явдал судлалын ухаанаар тодорхойлж гаргана. Тэгэхээр Монгол улс дах авлигын шалтгааныг эхлээд тодорхойлоё. Ингэхдээ нэгдүгээрт нийгмийн үзэгдэл болох талаас нь, харин дараа нь хууль зүйн факт болох талаас нь судалж юунаас болж авлига ба авлигын гэмт хэрэг ихээр гарах болсныг тогтоогоод дараа нь мөн тус тусад нь нийгмийн аргаар засаж залруулах, хууль зүйн аргаар засаж залруулах аргуудыг боловсруулж хэрэгжүүлэх шийдлээ танилцуулах нь зүйтэй мэт санагдана.

Миний бие суурь онолын болон ажиглалтын эмпирик судалгааны үндсэн дээр нийгмийн болоод хууль зүйн дараах шалтгаанууд нь авлигын эрсдэлийг бий болгох хүчин зүйл болж байна хэмээн үзэж байна.

- **Нийгэм бүхэлдээ ёс зүйн ухамсрын түвшин доогуур байна/нийгэмдээ нөлөөлж чадахуйц ёс зүйн систем байхгүй, уламжлалт шашны ёс зүйн**

системийг нь 20-р зуунд устгаснаас хойш дахин сэргээгүй, түүнийг нөхөж орлох, бүтээж бүрэлдүүлэх үйл явц өрнөөгүй/

- **Авлигын эрсдэл бүхий субъектүүдийн зан үйлийн хандлагыг зохицуулах хууль зүйн зохицуулалт дутмаг**
- Эрүүгийн хууль дах авлигын гэмт хэргийн зүйлчлэлийн нэр төрөл цөөн, хариуцлагыг санкц хөнгөн
- **Авлигын эсрэг үндэсний хэмжээний урт хугацааны стратегийн бодлого байхгүй** байна.
- Нийгэмд материаллаг байдлын хомсдол, төрийн үйлчилгээний шуурхай биш байдал, нийгмийн баялгийн тэгш биш хуваарилалт, иргэдийн хүсэл сонирхолд хүлээлт үүсгэх байдал зэрэг нь иргэдийг өөрсдөө санаачлагаараа авлига өгөх эрсдэлтэй байдалд хүргэдэг /эрүүл мэнд боловсролын салбар, төрийн албаны хүнд сурталтай хойрго үйлчилгээ, төрийн захиргааны байгууллагуудаас тогтоож олгодог хязгаарлалтууд(тусгай зөвшөөрөл, лиценз, квот, лимит гэх мэт нь авлигын такс болж тэдгээрийг худалдан авах далд үнэ тарифууд нэгэнт тогтсон)/

Дээрх нийтлэг хүчин зүйлүүд авлигын эрсдэлийг бий болгож байна. Нийгэмд ёс зүйн болон хуулийн зохицуулалт хомсдох үед эмх замбараагүй аномн байдал үүсэх ба энэ үед **далд хууль, нууц дүрмүүд** үйлчилж эхэлдэг. Төрийн үйлчилгээг авахын тулд албан бус үнэ тариф тогтох, иргэдээс шан харамж харах, шаардах, хэн хүчтэй, хэн мөнгөтэй нь асуудлаа өөртөө ашигтайгаар шийдүүлэх гэх мэт. Тухайлбал эрүүл мэндийн салбарт эрүүл мэндийн ямар үйлчилгээ авахаасаа хамаарч эмч болон холбогдох этгээдэд төлөх далд тариф тогтсон байдаг. Жирэмсэн эх нярайлахад эх барих эмчдээ/100 000 төгрөг хүртэл/, өвчтөн хүнд төрлийн мэс засал хагалгаанд ороход мэс засал удирдсан эмчид тодорхой хэмжээний мөнгө өгч талархлаа илэрхийлэх гэх мэт. Энэ бол хүн бүхний мэддэг нууц хууль.

Тэгвэл үүнийг хэрхэн залруулах вэ гэдэг асуултад дараах үндсэн 3 хүрээнд тодорхой шийдлүүдийг дэвшүүлж байна.

Нэгдүгээрт: Авлига нь нийгмийн үзэгдэл болохын хувьд нийгмийн ёс суртахууныг хөгжүүлэх замаар ухамсрын аргаар авлигаас татгалзах. Үүнд шашин шүтлэг болон бусад үзэл суртал, үзэл санааны арга хэрэгслийг соён гэгээрүүлэх замаар нэвтрүүлэх.

Хоёрдугаарт: Эдийн засгийн шалтгаанаас хамаарч авлигын эрсдэл үүсч байгааг төрийн бодлогоор засч залруулах. Төр засгийн үйлчилгээний хүртээмж, түүний материаллаг баазыг сайжруулах, төрийн үйлчилгээний ачааллыг бууруулах гэх мэт. Жишээ нь: хүн амын эрүүл мэндийн салбарын хэрэгцээнд 10 000 хүн тутмын дунд нэг эмнэлэг барьснаар очер дугаарлалтгүй, танил тал хөөцөлддөггүй, асуудлаа шуурхай шийдүүлэхийн тулд мөнгө санал болгох авлигын эрсдэл үүсэхгүй болно гэсэн үг. Зөвхөн эрүүл мэндийн салбарт л гэхэд хэт ачааллаас үүдэж дараалалд зогсож хүлээлт үүссэн иргэд өөрсдөө сэдэл санаачлагаараа танил тал хайх, мөнгө санал болгож асуудлаа хурдан шийдүүлэхийг эрмэлздэг. Энэ нь авлигын эрсдэлийг бий болгож байгаа тодорхой жишээ юм. Эмнэлэг хүрэлцээтэй, дараалал байхгүй бол энд авлига санал болгох шаардлага үүсэхгүй.

Гуравдугаарт: Авлига нь хууль зүйн зөрчил болохын хувьд түүнийг эрх зүйн системд бүрэн цогцоор хуульчилж өгөх шаардлагатай. Авлигын эсрэг заалтуудыг эрх зүйн эх сурвалжуудад хууль зүйн хүчин чадлаар нь шатчилан бүхий л заалтуудыг шигтгэж оруулж өгөх хэрэгтэй. Авлигын эсрэг заалтуудыг миний хүссэн төсөөллөөр хуулийн системд эрх зүйн хүчин чадлаар нь эрэмбэлбэл:

1. Авлигын эсрэг олон улсын гэрээ
2. Үндсэн хуульд авлигын эсрэг бүлэг заалт оруулах /эсхүл нэмэлт/
3. Авлигын эсрэг ердийн хууль /органик хууль(Эрүүгийн хуульд авлигын гэмт хэргийн шинжтэй гэмт явдлуудыг шинээр гэмт хэрэгт тооцож хуульчлах, тэдгээрийн хариуцлага санкцыг нэмэх, ялын бодлогыг чангатгах)/
4. Авлигын эсрэг хуульчилсан акт /зарлиг, захирамж, тогтоол/

5. Авлигын эсрэг шүүхийн жишиг /шүүхийн шийдвэр/
6. Авлигын эсрэг ёс зүйн хэм хэмжээнүүд /салбар салбарын ёс зүйн кодууд/
7. Авлигын эсрэг эрх зүйн номлол, үзэл баримтлал /эрдэмтэн судлаачдын бүтээл, эшлэл/
8. Авлигын эсрэг бусад эрх зүйн баримт бичгүүд

Авлигын эсрэг бүхий л үзэл санааг зүйлчлэн Монгол улсын эрх зүйн тогтолцоон дах хууль тогтоомжийн системд оруулж өгснөөр авлигын гэмт хэрэгтэй тэмцэх хууль эрх зүйн орчин төгөлдөржиж байгаа юм.

Авлигын гэмт хэргийг үйлдэх, хариуцлагаас мултрах, хариуцлагад татагдахгүй байх нэг хүчин зүйл бол авлигын эрсдэл бүхий субъектүүд/авлигын гэмт хэрэг үйлдэх эрх бүхий албан тушаалтнууд/ийн хууль зүйн хамгаалалт. Үндсэн хууль болон органик хуулиудаар албан тушаалтнуудын эрх дархыг хэтэрхий дөвийлгөж хуульчилсан байдаг. Энэ нь авлигын гэмт хэргийг дэвэргэх, гэмт хэрэг үйлдэх таатай халхавч болдог төдийгүй хууль сахиулахын байгууллагын үйл ажиллагаанд саад бэрхшээл учруулдаг. Үүнийг хууль зүйн шинэчлэлийн бодлогынхоо хүрээнд зарим дархлагдсан эрхүүдийг хасах, хязгаардах хэрэгтэй байна. Жишээ нь УИХ-н гишүүний халдашгүй байдлыг зөвхөн парламентын чуулганы үед хэрэглэх, бусад цагт халдашгүй дархан эрх үйлчлэхгүй байх гэх мэт. Өндөр албан тушаал хашиж байхдаа гэмт хэрэг үйлдсэн этгээд бүрэн эрхийн хугацаагаа дуустал эрх дархаараа хаацайлж хуулийн байгууллагын ажиллагаанаас холуур өнгөрч байгаад хугацаагаа дуусмагц дараагийн халдашгүй дархан эрх бүхий албан тушаалд очиж хуяглан суусаар хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дуусгах, тэр хэргийг замхраах байдлууд тодорхой баримт жишээтэйгээ манай улс төрийн хүрээнийхэн дунд байсаар байна.

Авлигын гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүйн аргын шинэ хандлагыг тодорхойлох нь:

Эрүүгийн эрх зүйн тодорхой арга бол нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцож, хариуцлага хүлээлгэх механизм юм. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол улсын Эрүүгийн хууль/2002 онд батлагдсан/-д 3 төрлийн гэмт хэргийг авлигын гэмт хэрэгт тооцож хуульчилсан байдаг. Энэ нь ЭХТА-н 268/хээл хахууль авах/, 269/хээл хахууль өгөх/, 270/хээл хахуульд зуучлах/-дугаар зүйлүүд бөгөөд энэ гэмт хэргийн хариуцлагын санкц нь нийгмийн хор аюулын хэр хэмжээнээсээ хэтэрхий хөнгөн байдаг.

Эдгээр нэр төрлийн авлигын гэмт хэргээс гадна авлигын шинжтэй, авлигын гэмт хэргийн бүрэлдэхүүнийг агуулсан гэмт явдлыг авлигын гэмт хэрэгт тооцон эрүүгийн хуульд багтааж хуульчлах шаардлагатай байдаг. Энэ нь хууль зүйн шинжлэх ухаан талаасаа нийгэмд аюултай үйлдэл үйлдсэнийх нь төлөө ял хэрэгдэхээр айлган сүрдүүлэх арга хэрэглэж байгаа нэг төрлийн эрүүгийн эрх зүйн арга юм. Үүнийг гол төлөв хуучин социалист эрх зүйн бүлд хамаарах улс орнууд буюу пост-социалист орнууд хэрэглэдэг. Хэдийгээр энэ арга нь хүний эрхийн байгууллагууд болон хүний эрхийн төлөө тэмцэгчдийн шүүмжлэлийг дагуулдаг ч эрүүгийн нөхцөл байдал хүнд орнуудад үр дүн сайтай байдаг байна. Миний тодорхойлсноор авлигын гэмт хэрэгт тооцож болох, улмаар эрүүгийн хуульд тусгаж хуульчлах дараах нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй нэрлэж байна. Жагсаавал:

1. Авлигын гэмт хэргийг нуун далдлах/авлигын гэмт хэргийг санаатай нуун далдлах/
2. Авлигын гэмт хэргийг үл мэдээлэх /авлигын гэмт хэргийг мэдээлэхгүй орхих/
3. Авлигын гэмт хэрэгт оролцох/авлига өгч авалцахад хамтрах/
4. Авлигын эрсдэл бий болгох /хясан боогдуулах замаар зориуд авлига авах, өгөх нөхцөл үүсгэх/
5. Албан тушаалтан өөртөө авлига өгөхийг санал болгох/өөртөө авлига өгөхийг тулган шаардахгүйгээр санал болгох/
6. Албан тушаалтан өөртөө авлига өгөхийг шаардах/албан тушаалтан авлига өгөхийг хүчилж тулган шаардах, албадах/

7. Бусдад авлига өгөхийг санал болгох/гуравдагч этгээд хөндлөнгөөс албан тушаалтанд авлига өгөхийг санал болгох/
8. Албан тушаалтанд авилга авахыг санал болгох/гуравдагч этгээд хөндлөнгөөс албан тушаалтанд хэн нэгнээс авлига авахыг санал болгох/
9. Авлига авахыг ятгах/албан тушаалтанд хэн нэгэн гуравдагч этгээд хөндлөнгөөс авлига авахыг ятгаж сэнхрүүлэх, зөвлөх/
10. Авлига өгөхийг ятгах/хэн нэгэнд гуравдагч этгээд хөндлөнгөөс албан тушаалтанд авлига өгөхийг ятгаж сэнхрүүлэх энэ талаар зөвлөгөө өгөх/

Дээрх гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй нь нийгэмд аюултай шинж чанараараа гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангаж байгаа бөгөөд үүний субъект нь албан тушаалтан болон авлига өгч буй болон оролцож буй этгээд, субъектив тал нь шууд ба шууд бус санаатай, объект нь төр түүний хэвийн үйл ажиллагаа, төрийн албаны нэр хүнд, объектив тал нь идэвхтэй үйлдэл юм.

Авлигагүй нийгмийг хөгжүүлэхийн тулд дээрх санал шийдлүүдийг хэрэгжүүлэх хэрэгтэй ба үүнийг цогцоор нь авч үзэхийн тулд үндэсний хэмжээнд хэрэгжих томоохон хэмжээний төрийн бодлогыг баталж гаргах зорилт тавьж хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, нийгмийн шударга ёсыг бэхжүүлэх, бусад салбаруудын бодлоготой уялдуулан салбар дундын хамтын удирдлагыг хэрэгжүүлэх гэх мэт. Энэ баримт бичиг нь томъёоллын хувьд "АВЛИГЫН ЭСРЭГ СТРАТЕГИЙН БОДЛОГО" нэртэй байвал зохимжтой бөгөөд салбар бүрт авлигын эсрэг дэд хөтөлбөрүүдийг багтаасан цогц стратегийн баримт бичиг болох нь чухал юм.

Уг бодлогын баримт бичгээр авлигатай тэмцэх үйл ажиллагааг богино, дунд, урт гэсэн хугацаанд хуваан зорилт тавьж богино болон дунд хугацаанд авлигын эсрэг хууль тогтоомжуудаа боловсронгуй болгож сайжруулах, холбогдох хуулиудаа уялдуулах, энэ чиглэлээр олон улсын нийгэмлэгүүдтэй хамтран ажиллах, авлигатай тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх хууль сахиулахын байгууллагынхаа чадавхи, дэд

бүтэцийг төгөлдөржүүлэх, хүний нөөц боловсон хүчнээ өргөтгөх, техник хэрэгслээ сайжруулах зэрэг алхмуудыг хэрэгжүүлэх нь оновчтой.

Авлигын эсрэг стратегийн урт хугацааны бодлого нь нийгмийн сэтгэл зүй, ёс зүйд нөлөөлөх боловсрол, нөлөөллийн бодлого явуулж хүн амын дунд ёс суртахууны ухамсрыг дээшлүүлэх байдалд чиглэх нь зүйтэй.

Монгол улсын авлигатай тэмцэх үйл ажиллагаанд энэ чиглэлийн олон улсын институци болох Зүүн Европ, Төв Азийн авлигын сүлжээ байгууллага эерэг үнэлгээ гаргаж дүгнэсэн ба гэхдээ анхаарах хэд хэдэн зүйл байгааг хэлснийг дурдах нь зүйтэй. Хууль тогтоох байгууллагаас ойр ойрхон өршөөлийн хууль гаргах нь авлигатай тэмцэх үйл ажиллагаа явуулдаг хууль сахиулахын байгууллагын үйл ажиллагааг үр дүнгүй болгодог, мөн авлигын гэмт хэрэгтнүүдэд ял завших боломж олгодгийг хэлсэн. Мөн түүнчлэн эх барьж буй нам авлигын эсрэг үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг улс төрийн зорилгоор ашиглах оролдлого гардгийг анхааруулаад энэ эрсдлийг тойрч гарахыг зөвлөсөн юм. Бас олон улсын санхүүгийн байгууллага болон гадаадын зээл тусламж нь авлигын замаар орж жинхэнэ очих ёстой эзэн ард түмэнд хүрэхгүй замаасаа алга болж байгаа авлигын ийм шинэ төрөл хүчээ авч байгаа нь санхүүгийн донор орнуудын итгэлийг алдуулах муу талтай тул энэ тал дээр авлигатай тэмцэх үйл ажиллагаагаа сайжруулах хэрэгтэйг мөн дурджээ.

Миний бие амьдарч буй нийгмээ ажиглаж, түүний үйл явц үзэгдлийг үнэлж дүгнэж явдаг иргэн хүнийхээ хувьд манай энэ цаг үеийн хөгжлийн хамгийн том чөдөр тушаа болсон нүдэнд үзэгддэггүй нийгмийн хорт хавдрыг хэрхэн анагаах вэ гэдэг санал санаачлагаа илэрхийллээ. Дээрх эссэгээ товчхон дүгэнэхэд **“Аноми байдлаас “хууль+ёс зүйн хэм хэмжээ” = авлиагүй нийгэм**-д хүрэх томъёолж Хууль болон ёс зүйн хэм хэмжээг багтаасан **АВЛИГЫН ЭСРЭГ 15 жилийн СТРАТЕГИЙН БОДЛОГО** гаргаж хэрэгжүүлбэ.

Ц.Чойжамц 80804335, 88742189, 88169770 @ardiinjirgeech.twitter.com

